

АЛТАЙ ЗАМ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо:	2021.03.28	
Эхэлсэн цаг:	16:00	
Дууссан цаг	16:55	
Хаана:	Улаанбаатар хот. СХД 38-р хороо, “Алтайн Зам” ХК – ийн хурлын танхим	
Хурлын төрөл:	☒ Ээлжит хурал	☐ Ээлжит бус хурал
Дугаар:		

Хурлын ирц

1	М.Нямдаваа	ТУЗ-ийн дарга	☒ ирсэн	☐ ирээгүй
2	С.Балжинням	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
3	Ц.Ганцэцэг	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
4	Г.Сономжамц	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
5	Б.Бат-Ирээдүй	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
6	С.Баянчулуун	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
7	С.Баянмөнх	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
8	Т.Мөнгөнцацрал	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
9	Н.Энхцэцэг	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
10	Э.Өлзийхутаг	Тооллогын	☒ ирсэн	☐ ирээгүй
		комиссын дарга		
11	Б.Бат-Эрдэнэ	Тооллогын гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
12	Д.Дэлгэрсүрэн	Тооллогын гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
13	Б.Энхбат	Гүйцэтгэх захирал	☒ ирсэн	☐ ирээгүй

М.Нямдаваа: Хуралдаа оролцож байгаа та бүхэнд баярлалаа. Энэ удаагийн хурал цар тахал бүрэн намжаагүйн улмаас ахин цахим хэлбэрээр зохион байгуулагдаж байгаа. Цахим хэлбэрээр зохион байгуулж байгаатай холбоотойгоор хуралдааны зохион байгуулагчаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Буянзаяа ажиллана. Хуралдаан үндсэн дэгийнхээ дагуу явагдана.

Б.Буянзаяа: Сайн байцгаана уу. Өнөөдрийн хуралдаанд 92 хувийн хувьцаа эзэмшигч Ньюпрогресс Групп ХХК-ийг төлөөлөн Сандагийн Балжинням 2022 оны 03 сарын 25-ны өдрийн 22/59 тоот итгэмжлэлээр оролцож байна. Ингээд хуралдааны ирц хуульд заасан шаардлагыг хангаж байгаа тул хуралдааныг нээж байна.

Тооллогын комиссын дарга Э.Өлзийхутаг: Алтайн Зам ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны ээлжит хуралдаанд 50056 ширхэг хувьцаа эзэмшигч Ньюпрогресс Групп ХХК-ийг итгэмжлэлээр төлөөлөн С.Балжинням оролцохоор бүртгүүлсэн байна. Өөр хувьцаа эзэмшигч хуралдаанд оролцохоор бүртгүүлээгүй бөгөөд урьдчилан санал ирүүлсэн хувьцаа эзэмшигч байхгүй болно гэсэн агуулга бүхий АЗТК001 тоот тооллогын комиссын тогтоол танилцуулав.

	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Ньюпрогресс Групп ХХК-ийг төлөөлөн С.Балжинням	50056 ширхэг	92%
	Нийт	50056 ширхэг	92%

Б.Буянзаяа: Та бүхэнд программын баруун доод буланд байгаа талбар дээр тогтоолуудын төслийг илгээсэн байгаа. Та бүхэн татаж авч танилцаж болно. Түүнчлэн чат хэлбэрээр асуулга асуух болон санал

өгөх боломжтой. Бид хуралдааны дараа халдвар хамгааллын дэглэмийг сахин та бүхнээр баталгаажуулж гарын үсэг зуруулна.

Б.Буянзаяа хуралдааны дэг болон хэлэлцэх асуудлын тухай товч танилцуулга хийж, өмнө гарсан ТУЗ-ийн тогтоолуудыг танилцуулав.

М.Нямдаваа: Хувьцаа эзэмшигчдэд тогтоолын төслийг урьдчилан танилцуулсан тул санал хураалтыг эхлүүлэе.

Хувьцаа эзэмшигч нарт санал байхгүй гэснээр дараах товлосон асуудлын хүрээнд санал хураалтыг эхлүүлж тооллогын комиссын АЗТК002 тоот тогтоолыг комиссын дарга Э.Өлзийхутаг танилцуулав.

	Хэлэлцсэн асуудал	Тогтоолын төслийн дугаар	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт	АЗХЭ2022001	50056	0	0
2	ТУЗ-ийн 2020 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай	АЗХЭ2022002	50056	0	0
3	ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай	АЗХЭ2022003	50056	0	0
4	УБГ дээрх хөрөнгийн хэмжээ болон хувьцааны тоог залруулах тухай	АЗХЭ2022004	50056	0	0

Шийдвэрлэсэн нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцон хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр АЗХЭ2022001, АЗХЭ2022002, АЗХЭ2022003, АЗХЭ2022004 тоот тогтоолын төслүүдийг баталж, Тогтоолыг албажуулах үүргийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Буянзаяад үүрэг болгов.

М.Нямдаваа: Энэ удаагийн ээлжит хуралдааныг үүгээр хааж байна.

Хуралдаан 2022 оны 3 сарын 28-ны 16:55 цагт өндөрлөв.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

ТУЗНБД

ХЯНАСАН

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ



Б.БУЯНЗАЯА

М.НЯМДАВАА

С.БАЛЖИННЯМ